



2019 оны 05 дугаар сарын 30  
№21/1074/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын  
хууль**

**Ус бохирдуулсны төлбөрийн  
тухай хуульд нэмэлт, өөрчлөлт  
оруулах тухай**

**Монгол Улсын  
хууль**

**Усны тухай хуульд нэмэлт,  
өөрчлөлт оруулах тухай**

**Монгол Улсын  
Их Хурлын  
тогтоол**

**Зарим газар нутгийг  
улсын тусгай хамгаалалтад  
авах тухай**

## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

172.	Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		661
173.	Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		663
174.	Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		665
175.	Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		665
176.	Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		666

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

177.	Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай	Дугаар 41	667
178.	Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай	Дугаар 49	682
179.	Цахим бодлогын түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 50	682

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

180.	Үндэсний хөтөлбөр батлах тухай	Дугаар 69	683
------	--------------------------------	-----------	-----

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 05 дугаар  
сарын 02-ны өдөр

Улаанбаатар  
хот

#### УС БОХИРДУУЛСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

**1/4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг:**



“4.3.Сав газрын захиргаа, эсхүл сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 4.2 дахь хэсэгт зааснаас бусад ус бохирдуулагчийн талаарх мэдээллийг харьяалах татварын албанд хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл олгосон өдрөөс хойш нэг сарын дотор гарган өгч, татварын алба уг мэдээллийг үндэслэн төлбөр төлөгчийг бүртгэнэ.”

**2/8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт:**

“8.1.3.хаягдал усыг цэвэрлэх байгууламж ашиглан хаягдал усны стандартын түвшинд хүртэл цэвэрлэж байгаа нь тогтоогдсон бол цэвэрлэх байгууламж суурилуулан ашигласан өдрөөс эхлэн гурван жилийн хугацаагаар.”

**2 дугаар зүйл.** Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “бага” гэсний дараа “, аюултай бохирдуулах бодис агуулаагүй” гэж, 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн “цэвэрлэдэг болон” гэсний дараа “төсвөөс санхүүждэг” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг:**

“4.2.Сав газрын захиргаа, эсхүл сум, дүүргийн Засаг даргатай ус бохирдуулсны төлбөрийн гэрээ байгуулсан хот, суурин газрын ахуйн болон үйлдвэрийн хаягдал усыг цэвэрлэдэг хуулийн этгээд нь ус бохирдуулагчийн талаарх мэдээллийг харьяалах татварын албанд хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл олгосон өдрөөс хойш нэг сарын дотор гарган өгч, татварын алба уг мэдээллийг үндэслэн төлбөр төлөгчийг бүртгэнэ.”

**2/7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг:**

“7.1.Төлбөрийн хэмжээг хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээнд үндэслэн дараах хязгаарт багтаан Засгийн газар тогтооно:

Бохирдуулах бодис	Хэмжих нэгж	Төлбөрийн хязгаар /төгрөгөөр/	
		доод	дээд
Жинлэгдэх бодис	килограмм	50	1000
Органик бодис	килограмм	50	1000
Эрдэс бодис	килограмм	20	400
Хүнд металл	килограмм	500	10000
Аюултай бохирдуулах бодис	грамм	1000	10000

**3/7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг:**

“7.3.Төлбөрийн орлогыг Байгаль орчин, уур амьсгалын санд төвлөрүүлэн, усны нөөцийг хамгаалах, усны бохирдлыг арилгах, хяналт-шинжилгээ хийх, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах ба орлогын 50-иас доошгүй хувийг цэвэрлэх байгууламжийн шинэчлэл, засвар үйлчилгээнд зарцуулна.”

**4/9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг:**

“9.3.Төлбөрийн тайлангийн маягыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.”

**4 дүгээр зүйл.**Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “холбогдох” гэснийг “хот, суурины ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн” гэж, 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн “Улсын болон аймгийн зэрэглэлтэй хот” гэснийг “Хот” гэж, 9 дүгээр зүйлийн 9.2.3 дахь заалтын “усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад” гэснийг “байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад” гэж, 4 дүгээр зүйлийн “4.3” дахь хэсгийн дугаарыг “4.4” гэж, “4.4” дэх хэсгийн дугаарыг “4.5” гэж, “4.5” дахь хэсгийн дугаарыг “4.6” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын “, эсхүл аюултай бохирдуулах бодис гаргадаг” гэснийг хассугай.

**6 дугаар зүйл.**Энэ хуулийг 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2019 оны 05 дугаар  
сарын 02-ны өдөр

Улаанбаатар  
хот

**УСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Усны тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

**1/25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсэг:**

“25.3.Энэ хуулийн 17.1.13 дахь заалтад заасан гэрээний загвар болон 25.2 дахь хэсэгт заасан шатлан өсгөх хэлбэрээр нөхөн төлбөрийн хэмжээг тооцох журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

**2/17 дугаар зүйлийн 17.1.13 дахь заалт:**

“17.1.13.хаягдал усыг зохих журмын дагуу байгальд шууд нийлүүлж байгаа хуулийн этгээдтэй ус бохирдуулсны төлбөрийн гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллах.”

**2 дугаар зүйл.**Усны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалтын “хот, суурины” гэсний дараа “ус хангамж,” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Усны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“25.2.Ус бохирдуулагч нь бохирдуулах бодисыг хаягдал усны стандартад заасан хэмжээнээс хэтрүүлэн гаргасан тохиолдолд байгаль орчны итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтийг үндэслэн байгаль орчны байцаагч ус бохирдуулсны нөхөн төлбөрийг ногдуулж, төлөлтөд хяналт тавих бөгөөд нөхөн төлбөрийн хэмжээг ус бохирдуулсны төлбөрийг хоёроос тав дахин шатлан өсгөх хэлбэрээр нэмэгдүүлж, бохирдуулах бодис бүрээр тогтооно.”

**4 дүгээр зүйл.**Усны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн “хөтөлбөрийг” гэснийг “хөтөлбөр, усны шинжилгээний аргачлалыг” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтын “усны хяналт-шинжилгээ хийх” гэснийг “усны хэрэглээний норм тогтоох, усны чанарыг бохирдлын индексээр үнэлэх” гэж, 17 дугаар зүйлийн “17.1.13” дахь заалтын дугаарыг “17.1.14” гэж, 25 дугаар зүйлийн “25.3” дахь хэсгийн дугаарыг “25.4” гэж, “25.4” дэх хэсгийн дугаарыг “25.5” гэж, “25.5” дахь хэсгийн дугаарыг “25.6” гэж, “25.6” дахь хэсгийн дугаарыг “25.7” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Усны тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**6 дугаар зүйл.**Энэ хуулийг Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 05 дугаар  
сарын 02-ны өдөр

Улаанбаатар  
хот

### АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“56.1.5. тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчинд хортой нөлөөлж байгаа, эсхүл нөхөн сэргээх, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан үүргээ биелүүлээгүй талаар нутгийн захиргааны байгууллагын саналыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дүгнэлт гаргасан,”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 05 дугаар  
сарын 02-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

**1/33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсэг:**

“33.6. Усны сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүс болон ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсэд иргэн, хуулийн этгээдэд газар ашиглуулах, эзэмшүүлэхийг хориглоно.”

**2 дугаар зүйл.** Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсгийн “иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тухайн газрыг” гэсний дараа “аймаг, нийслэлийн байгаль орчны газрын дүгнэлтийг үндэслэн” гэж нэмсүгэй.



**3 дугаар зүйл.**Газрын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг:**

“15.1.Усны сан бүхий газарт нуур, цөөрөм, тойром, гол мөрөн, горхи, булаг, шанд, усан сан, рашаан, намаг, мөстөл, мөсөн голын эзэлж байгаа талбай, тэдгээрийн хамгаалалтын бүсийн газар хамаарна.”

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2019 оны 05 дугаар  
сарын 02-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Газрын төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтын “байгууллагыг” гэсний дараа “улсын тусгай хамгаалалттай газраас бусад газар дахь” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Газрын төлбөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“4.Уурхайн эдэлбэрийн ашиглалт явуулж байгаа хэсэгт зохих хууль тогтоомж, гэрээний дагуу үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газрын төлбөрийг ойр орших улс, аймгийн зэрэглэлтэй хотын бүсэд хамааруулан хоёр дахин өсгөж тооцно.

5.Ойн сан бүхий газар болон усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд зохих хууль тогтоомж, гэрээний дагуу үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газрын төлбөрийг ойр орших улс, аймгийн зэрэглэлтэй хотын бүсэд хамааруулан хоёр дахин өсгөж тооцно.”

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 05 дугаар  
сарын 02-ны өдөр

Дугаар 41

Улаанбаатар  
хот

### **Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай**

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Байгалийн бүс, бүслүүрийн онцлог хэв шинж, унаган төрх, байгалийн өвөрмөц тогтоц, түүх, соёлын дурсгалыг хадгалах, ховордсон ургамал, амьтныг хамгаалах зорилгоор түүх, соёл, шинжлэх ухаан, танин мэдэхүй, экологийн хувьд онцгой ач холбогдол бүхий зарим газар нутгийг доор дурдсан ангиллаар улсын тусгай хамгаалалтад авсугай:

1/Дарьгангын байгалийн цогцолборт газрын хилийн заагт Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутагт орших Шилийн богд уул, Хөргийн хөндийн байгалийн дурсгалт газрыг хамруулж, ангилал дээшлүүлэн байгалийн цогцолборт газрын ангиллаар;

2/Хөвсгөл аймгийн Цагаан-Уул, Цэцэрлэг, Шинэ-Идэр, Бүрэнтогтох сум, Завхан аймгийн Тэлмэн, Их-Уул сумын нутгийг дамнан орших Тэсийн гол, Булнайн нурууг байгалийн цогцолборт газрын ангиллаар;

3/Дорноговь аймгийн Хөвсгөл сумын нутагт орших Гүн гашууны хоолойг байгалийн нөөц газрын ангиллаар;

4/Дорнод аймгийн Баяндун сумын нутаг дэвсгэрт орших Баяндун уулыг байгалийн нөөц газрын ангиллаар;

5/Дорнод аймгийн Баянтүмэн сумын нутагт орших Халхын таван уулыг байгалийн нөөц газрын ангиллаар;

6/Дорнод аймгийн Матад сумын нутагт орших Мэнэнгийн цагаан хоолойг байгалийн нөөц газрын ангиллаар;

7/Дорнод аймгийн Матад сумын нутагт орших Жаран тогооны тал “А” хэсгийг байгалийн нөөц газрын ангиллаар;

8/Дорнод аймгийн Матад сумын нутагт орших Жаран тогооны тал “Б” хэсгийг байгалийн нөөц газрын ангиллаар;





9/Дорнод аймгийн Халхгол сумын нутагт орших Ташгайн таван нуурыг байгалийн нөөц газрын ангиллаар;

10/Дорнод аймгийн Чойбалсан сумын нутагт орших Хөх нуурыг байгалийн нөөц газрын ангиллаар;

11/Өвөрхангай аймгийн Хархорин, Хужирт, Өлзийт сумын нутгийг дамнан орших Дулаан хайрхан уулыг байгалийн нөөц газрын ангиллаар;

12/Онгон таван булгийн байгалийн нөөц газрын хилийн заагт Сүхбаатар аймгийн Баяндэлгэр, Ongon сумын зарим газар нутгаар өргөтгөн байгалийн нөөц газрын ангиллаар;

13/Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт орших Зотол хаан уулыг байгалийн нөөц газрын ангиллаар;

14/Ховд аймгийн Дарви, Цэцэг сум, Говь-Алтай аймгийн Тонхил, Дарви сумын нутгийг дамнан орших Сутай хайрхан уулыг байгалийн нөөц газрын ангиллаар;

15/Хэнтий аймгийн Баян-Адарга, Норовлин, Батноров сумын нутагт орших Улз голын эхийг байгалийн нөөц газрын ангиллаар;

16/Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутагт орших Дэлгэрхаан уулыг байгалийн нөөц газрын ангиллаар;

17/Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших Цагаан дэлийн агуйг байгалийн дурсгалт газрын ангиллаар.

2.Байгаль орчны тэнцлийг хангах, унаган төрхийг хадгалах, хамгаалах болон байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор улсын тусгай хамгаалалттай зарим газар нутгийн хилийн заагийг доор дурдсанаар шинэчлэн тогтоосугай:

1/Говийн их дархан цаазат газрын “Б” хэсгийн хилийн заагт Ховд аймгийн Булган, Үенч, Алтай сум, Говь-Алтай аймгийн Тонхил, Бугат сумын зарим хэсгийг хамруулан уг дархан цаазат газрын хилийн заагийг 1 дүгээр хавсралтаар;

2/Отгонтэнгэрийн дархан цаазат газрын хилийн заагт Завхан аймгийн Отгон сумын зарим хэсгийг хамруулан уг дархан цаазат газрын хилийн заагийг 2 дугаар хавсралтаар;



3/Нөмрөгийн дархан цаазат газрын хилийн заагт Дорнод аймгийн Халхгол сумын зарим хэсгийг хамруулан уг дархан цаазат газрын хилийн заагийг 3 дугаар хавсралтаар;

4/Монгол дагуурын “Б” хэсгийн дархан цаазат газрын хилийн заагт Дорнод аймгийн Гурванзагал, Дашбалбар сумын зарим хэсгийг хамруулан уг дархан цаазат газрын хилийн заагийг 4 дүгээр хавсралтаар;

5/Булган гол-Их Онгогийн байгалийн цогцолборт газрын хилийн заагт Ховд аймгийн Булган, Үенч сумын зарим хэсгийг хамруулан уг байгалийн цогцолборт газрын хилийн заагийг 5 дугаар хавсралтаар.

3.Тэсийн гол, Булнайн нурууны байгалийн цогцолборт газрын хилийн заагийг 6 дугаар, Дарьгангын байгалийн цогцолборт газрын хилийн заагийг 7 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

4.Байгалийн нөөц болон дурсгалт газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хилийн заагийг тогтоохыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай.

5.Улсын тусгай хамгаалалтад авч байгаа газруудын хамгааллын менежментийг шинээр бүтэц орон тоо, цалингийн санг нэмэгдүүлэхгүйгээр баталсан орон тоо, төсөвт багтаан хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай.

6.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан “Улсын тусгай хамгаалалттай газрын ангиллыг шинэчлэн тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 1995 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 26 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын “1.Говийн их дархан цаазат газрын хилийн зааг”-ийн “Б” хэсгийг, “6.Нөмрөгийн дархан цаазат газрын хилийн зааг”-ийг, “8.Монгол дагуурын дархан цаазат газрын хилийн зааг”-ийн “Б” хэсгийг, “9.Отгонтэнгэр уулын дархан цаазат газрын хилийн зааг”-ийг, “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах болон улсын тусгай хамгаалалттай зарим газар нутгийн хилийн заагийг шинэчлэн тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2011 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 18 дугаар тогтоолын 8 дугаар хавсралтыг, “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай” Монгол Улсын Их Хурлын 2004 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 22 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**



Монгол Улсын Их Хурлын 2019 оны  
41 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

Говийн их дархан цаазат газрын "Б" хэсгийн хилийн зааг

№	Аймгийн нэр	Уртраг	Өргөрөг	Талбайн хэмжээ /га/
1	Ховд Говь-Алтай	93° 51' 17,442" E	45° 31' 42,730" N	1835724,94
2		94° 17' 49,781" E	45° 23' 36,597" N	
3		94° 24' 44,480" E	45° 21' 1,974" N	
4		94° 30' 32,420" E	45° 9' 21,695" N	
5		94° 31' 7,401" E	44° 58' 19,165" N	
6		94° 25' 58,560" E	44° 58' 12,806" N	
7		94° 25' 54,118" E	45° 3' 31,801" N	
8		94° 21' 10,700" E	45° 3' 30,790" N	
9		94° 21' 9,616" E	45° 5' 33,127" N	
10		94° 19' 19,920" E	45° 7' 49,457" N	
11		94° 13' 48,128" E	45° 7' 46,558" N	
12		94° 5' 23,832" E	45° 4' 27,059" N	
13		94° 5' 27,264" E	44° 53' 44,287" N	
14	Улсын хил дагуу			
15		90° 47' 12,969" E	45° 22' 19,264" N	
16		90° 57' 24,964" E	45° 20' 35,816" N	
17		91° 10' 26,425" E	45° 15' 55,989" N	
18		91° 11' 45,072" E	45° 12' 57,430" N	
19		91° 19' 9,375" E	45° 9' 55,332" N	
20		91° 19' 58,582" E	45° 9' 54,941" N	
21		91° 20' 3,623" E	45° 15' 39,635" N	
22		91° 8' 39,193" E	45° 24' 54,106" N	
23		91° 9' 10,261" E	45° 37' 8,728" N	
24		91° 22' 37,862" E	45° 50' 18,295" N	
25		92° 0' 0,512" E	45° 47' 11,530" N	
26		92° 17' 58,367" E	45° 40' 23,863" N	
27		93° 6' 19,469" E	45° 40' 16,771" N	
28		93° 6' 17,864" E	45° 37' 35,274" N	
29		93° 16' 47,406" E	45° 37' 32,624" N	
30		93° 16' 49,252" E	45° 35' 20,902" N	
31		93° 35' 19,423" E	45° 35' 19,676" N	
32		93° 38' 9,002" E	45° 31' 56,175" N	



Монгол Улсын Их Хурлын 2019 оны  
41 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

Отгонтэнгэрийн дархан цаазат газрын хилийн зааг

№	Аймгийн нэр	Уртраг	Өргөрөг	Талбайн хэмжээ /га/
1	Завхан	98° 11' 19,072" E	47° 54' 36,499" N	192747,99
2		98° 11' 16,071" E	47° 54' 23,022" N	
3		98° 11' 18,268" E	47° 54' 9,358" N	
4		98° 11' 27,250" E	47° 53' 58,110" N	
5		98° 11' 37,330" E	47° 53' 53,386" N	
6		98° 11' 49,360" E	47° 53' 35,176" N	
7		98° 12' 7,844" E	47° 53' 24,245" N	
8		98° 12' 51,432" E	47° 53' 8,603" N	
9		98° 13' 0,871" E	47° 53' 0,144" N	
10		98° 13' 8,736" E	47° 52' 52,659" N	
11		98° 13' 12,966" E	47° 52' 46,823" N	
12		98° 13' 9,485" E	47° 52' 36,661" N	
13		98° 13' 4,561" E	47° 52' 25,688" N	
14		98° 13' 2,089" E	47° 52' 17,421" N	
15		98° 13' 7,869" E	47° 51' 58,714" N	
16		98° 13' 9,303" E	47° 51' 53,336" N	
17		98° 13' 9,999" E	47° 51' 44,214" N	
18		98° 13' 5,507" E	47° 51' 35,408" N	
19		98° 13' 0,168" E	47° 51' 27,137" N	
20		98° 12' 51,919" E	47° 51' 21,527" N	
21		98° 12' 43,467" E	47° 51' 16,639" N	
22		98° 12' 37,315" E	47° 51' 15,842" N	
23		98° 11' 56,199" E	47° 51' 22,571" N	
24		98° 12' 3,171" E	47° 51' 14,440" N	
25		98° 12' 7,625" E	47° 51' 9,621" N	
26		98° 12' 13,420" E	47° 50' 59,198" N	
27		98° 12' 16,630" E	47° 50' 49,929" N	
28		98° 12' 16,359" E	47° 50' 45,699" N	
29		98° 12' 10,470" E	47° 50' 41,403" N	
30		98° 12' 5,098" E	47° 50' 38,228" N	
31		98° 12' 1,769" E	47° 50' 32,598" N	
32		98° 11' 51,877" E	47° 50' 7,749" N	
33		98° 11' 43,674" E	47° 49' 45,205" N	
34		98° 11' 41,828" E	47° 49' 23,203" N	
35		98° 11' 40,273" E	47° 49' 14,409" N	
36		98° 11' 39,747" E	47° 49' 6,835" N	
37		98° 11' 25,602" E	47° 48' 47,101" N	
38		98° 11' 29,502" E	47° 48' 24,153" N	



39	98° 11' 35,132" E	47° 48' 12,686" N
40	98° 11' 39,088" E	47° 48' 3,788" N
41	98° 11' 40,351" E	47° 47' 54,092" N
42	98° 11' 39,362" E	47° 47' 44,919" N
43	98° 11' 31,118" E	47° 47' 30,517" N
44	98° 11' 24,405" E	47° 47' 22,002" N
45	98° 11' 18,928" E	47° 47' 16,725" N
46	98° 11' 3,561" E	47° 47' 12,148" N
47	98° 10' 49,567" E	47° 47' 9,488" N
48	98° 10' 40,860" E	47° 47' 7,043" N
49	98° 10' 39,267" E	47° 47' 5,354" N
50	98° 10' 38,498" E	47° 47' 2,278" N
51	98° 10' 40,635" E	47° 46' 59,333" N
52	98° 10' 50,034" E	47° 46' 51,484" N
53	98° 11' 3,523" E	47° 46' 39,739" N
54	98° 11' 10,111" E	47° 46' 34,002" N
55	98° 11' 22,361" E	47° 46' 24,814" N
56	98° 11' 22,031" E	47° 46' 16,451" N
57	98° 11' 19,724" E	47° 46' 11,018" N
58	98° 11' 18,383" E	47° 46' 6,850" N
59	98° 11' 17,609" E	47° 46' 3,927" N
60	98° 11' 18,900" E	47° 45' 57,047" N
61	98° 11' 20,466" E	47° 45' 49,397" N
62	98° 11' 18,680" E	47° 45' 45,566" N
63	98° 11' 7,336" E	47° 45' 39,714" N
64	98° 10' 47,457" E	47° 45' 34,177" N
65	98° 10' 33,638" E	47° 45' 29,673" N
66	98° 10' 21,304" E	47° 45' 25,653" N
67	98° 10' 20,178" E	47° 45' 23,346" N
68	98° 10' 21,744" E	47° 45' 21,574" N
69	98° 10' 38,519" E	47° 45' 15,758" N
70	98° 10' 45,667" E	47° 45' 12,813" N
71	98° 10' 46,957" E	47° 45' 9,023" N
72	98° 10' 45,804" E	47° 45' 5,933" N
73	98° 10' 36,732" E	47° 44' 56,573" N
74	98° 10' 27,567" E	47° 44' 48,972" N
75	98° 10' 27,979" E	47° 44' 45,924" N
76	98° 10' 32,813" E	47° 44' 37,670" N
77	98° 10' 44,293" E	47° 44' 31,367" N
78	98° 10' 51,215" E	47° 44' 26,327" N
79	98° 11' 2,441" E	47° 44' 20,856" N
80	98° 11' 7,612" E	47° 44' 17,785" N
81	98° 11' 11,183" E	47° 44' 13,379" N



82	98° 11' 12,653" E	47° 44' 8,993" N
83	98° 11' 9,342" E	47° 43' 58,669" N
84	98° 11' 0,416" E	47° 43' 51,198" N
85	98° 10' 51,901" E	47° 43' 42,986" N
86	98° 10' 44,128" E	47° 43' 32,727" N
87	98° 10' 38,718" E	47° 43' 22,661" N
88	98° 10' 37,007" E	47° 43' 4,709" N
89	98° 10' 25,624" E	47° 42' 42,211" N
90	98° 10' 16,393" E	47° 42' 28,898" N
91	98° 10' 4,968" E	47° 42' 25,333" N
92	98° 9' 51,460" E	47° 42' 23,702" N
93	98° 9' 30,288" E	47° 42' 24,698" N
94	98° 9' 10,683" E	47° 42' 25,376" N
95	98° 8' 56,550" E	47° 42' 26,175" N
96	98° 8' 39,970" E	47° 42' 27,032" N
97	98° 8' 27,566" E	47° 42' 26,287" N
98	98° 8' 5,177" E	47° 42' 24,942" N
99	98° 7' 55,912" E	47° 42' 25,828" N
100	98° 7' 20,835" E	47° 42' 30,507" N
101	98° 7' 8,992" E	47° 42' 34,734" N
102	98° 6' 55,939" E	47° 42' 38,887" N
103	98° 6' 34,830" E	47° 42' 43,995" N
104	98° 6' 16,930" E	47° 42' 45,590" N
105	98° 5' 47,587" E	47° 42' 46,082" N
106	98° 5' 8,038" E	47° 42' 45,336" N
107	98° 4' 18,340" E	47° 42' 42,941" N
108	98° 3' 57,408" E	47° 42' 39,818" N
109	98° 3' 39,938" E	47° 42' 33,611" N
110	98° 3' 24,892" E	47° 42' 29,815" N
111	98° 3' 10,315" E	47° 42' 27,076" N
112	98° 2' 53,177" E	47° 42' 20,681" N
113	98° 2' 43,550" E	47° 42' 17,419" N
114	98° 2' 30,100" E	47° 42' 13,100" N
115	98° 2' 23,032" E	47° 42' 11,229" N
116	98° 2' 15,223" E	47° 42' 10,341" N
117	98° 2' 0,625" E	47° 42' 12,332" N
118	98° 1' 48,173" E	47° 42' 16,512" N
119	98° 1' 35,226" E	47° 42' 22,103" N
120	98° 1' 24,890" E	47° 42' 26,411" N
121	98° 1' 11,943" E	47° 42' 34,265" N
122	98° 0' 57,288" E	47° 42' 38,927" N
123	98° 0' 41,726" E	47° 42' 43,532" N
124	98° 0' 32,157" E	47° 42' 44,387" N



125		98° 0' 19,314" E	47° 42' 42,366" N
126		98° 0' 8,919" E	47° 42' 35,759" N
127		97° 59' 53,354" E	47° 42' 26,778" N
128		97° 59' 38,067" E	47° 42' 20,282" N
129		97° 59' 13,900" E	47° 42' 11,800" N
130		97° 58' 50,393" E	47° 42' 9,738" N
131		97° 58' 39,314" E	47° 42' 8,234" N
132		97° 58' 21,639" E	47° 42' 1,383" N
133		97° 58' 8,335" E	47° 41' 56,035" N
134		97° 57' 57,287" E	47° 41' 49,797" N
135		97° 57' 48,493" E	47° 41' 44,933" N
136		97° 57' 35,770" E	47° 41' 37,562" N
137		97° 57' 29,590" E	47° 41' 31,417" N
138		97° 57' 20,773" E	47° 41' 22,228" N
139		97° 57' 15,170" E	47° 41' 16,325" N
140		97° 57' 13,003" E	47° 41' 9,810" N
141		97° 57' 7,729" E	47° 41' 5,985" N
142		97° 57' 0,942" E	47° 41' 4,331" N
143		97° 56' 55,120" E	47° 41' 0,061" N
144		97° 56' 54,957" E	47° 40' 58,159" N
145		97° 56' 38,576" E	47° 40' 47,949" N
146		97° 56' 25,417" E	47° 40' 40,942" N
147		97° 55' 58,653" E	47° 40' 30,234" N
148		97° 55' 38,316" E	47° 40' 18,970" N
149		97° 55' 28,402" E	47° 40' 14,068" N
150		97° 55' 18,552" E	47° 40' 8,693" N
151		97° 54' 57,456" E	47° 39' 57,857" N
152		97° 54' 46,531" E	47° 39' 50,032" N
153		97° 54' 32,111" E	47° 39' 41,990" N
154		97° 54' 9,631" E	47° 39' 25,824" N
155		97° 54' 2,390" E	47° 39' 22,039" N
156		97° 53' 55,416" E	47° 39' 11,124" N
157		97° 53' 50,411" E	47° 39' 1,285" N
158		97° 53' 41,093" E	47° 38' 46,889" N
159		97° 53' 34,572" E	47° 38' 32,667" N
160		97° 53' 16,685" E	47° 38' 13,925" N
161		97° 53' 0,071" E	47° 37' 56,215" N
162		97° 52' 45,427" E	47° 37' 39,580" N
163		97° 52' 23,733" E	47° 37' 22,980" N
164		97° 52' 5,719" E	47° 37' 10,421" N
165		97° 51' 47,825" E	47° 37' 2,156" N
166		97° 51' 27,072" E	47° 36' 54,188" N
167		97° 51' 15,145" E	47° 36' 48,677" N



168	97° 51' 2,390" E	47° 36' 44,067" N
169	97° 50' 32,691" E	47° 36' 34,583" N
170	97° 50' 15,373" E	47° 36' 27,303" N
171	97° 50' 5,105" E	47° 36' 19,988" N
172	97° 49' 59,807" E	47° 36' 7,268" N
173	97° 49' 53,747" E	47° 35' 54,977" N
174	97° 49' 50,285" E	47° 35' 44,279" N
175	97° 49' 43,592" E	47° 35' 31,471" N
176	97° 49' 32,159" E	47° 35' 12,172" N
177	97° 49' 25,452" E	47° 35' 4,604" N
178	97° 49' 13,535" E	47° 34' 59,090" N
179	97° 48' 57,673" E	47° 34' 56,663" N
180	97° 48' 42,990" E	47° 34' 51,664" N
181	97° 48' 33,219" E	47° 34' 48,990" N
182	97° 48' 23,884" E	47° 34' 39,484" N
183	97° 48' 19,842" E	47° 34' 32,027" N
184	97° 48' 15,251" E	47° 34' 24,878" N
185	97° 48' 10,929" E	47° 34' 19,461" N
186	97° 47' 59,867" E	47° 34' 7,787" N
187	97° 47' 46,763" E	47° 33' 52,555" N
188	97° 47' 17,594" E	47° 33' 30,962" N
189	97° 48' 52,388" E	47° 30' 42,160" N
190	97° 45' 11,096" E	47° 28' 40,816" N
191	97° 39' 5,609" E	47° 31' 20,681" N
192	97° 36' 27,790" E	47° 32' 29,538" N
193	97° 31' 21,107" E	47° 30' 32,574" N
194	97° 30' 31,064" E	47° 31' 26,751" N
195	97° 28' 38,344" E	47° 33' 13,304" N
196	97° 24' 28,653" E	47° 32' 50,178" N
197	97° 18' 20,583" E	47° 34' 34,892" N
198	97° 18' 18,496" E	47° 34' 35,510" N
199	97° 18' 18,496" E	47° 34' 35,510" N
200	97° 15' 25,901" E	47° 36' 7,136" N
201	97° 15' 38,645" E	47° 37' 42,634" N
202	97° 15' 52,487" E	47° 38' 10,292" N
203	97° 16' 2,979" E	47° 38' 35,849" N
204	97° 15' 58,310" E	47° 39' 9,824" N
205	97° 15' 48,999" E	47° 39' 39,488" N
206	97° 15' 27,961" E	47° 39' 46,807" N
207	97° 16' 34,098" E	47° 40' 27,251" N
208	97° 16' 48,573" E	47° 41' 11,416" N
209	97° 19' 3,402" E	47° 47' 18,359" N
210	97° 22' 36,015" E	47° 48' 42,308" N





211		97° 25' 53,027" E	47° 48' 52,457" N	
212		97° 25' 53,028" E	47° 48' 52,457" N	
213		97° 27' 31,108" E	47° 48' 48,337" N	
214		97° 27' 31,108" E	47° 48' 48,337" N	
215		97° 33' 18,963" E	47° 47' 45,880" N	
216		97° 35' 32,227" E	47° 48' 3,554" N	
217		97° 36' 4,032" E	47° 47' 12,632" N	
218		97° 38' 35,891" E	47° 45' 27,493" N	
219		97° 39' 6,323" E	47° 42' 59,727" N	
220		97° 41' 47,630" E	47° 42' 46,296" N	
221		97° 41' 59,660" E	47° 43' 31,766" N	
222		97° 44' 32,126" E	47° 48' 3,210" N	
223		97° 45' 52,487" E	47° 50' 26,047" N	
224		97° 47' 43,477" E	47° 50' 55,778" N	
225		97° 48' 32,531" E	47° 51' 38,364" N	
226		97° 49' 2,468" E	47° 53' 30,837" N	
227		97° 53' 20,208" E	47° 54' 23,502" N	
228		97° 56' 25,327" E	47° 53' 37,717" N	
229		98° 2' 38,011" E	47° 56' 11,910" N	
230		98° 10' 29,791" E	47° 57' 1,335" N	
231		98° 10' 32,787" E	47° 57' 1,841" N	
232		98° 11' 9,276" E	47° 56' 23,274" N	
233		98° 11' 28,129" E	47° 55' 57,326" N	
234		98° 11' 30,491" E	47° 55' 48,152" N	
235		98° 11' 30,024" E	47° 55' 31,851" N	
236		98° 11' 27,991" E	47° 55' 26,083" N	
237		98° 11' 20,768" E	47° 55' 16,484" N	
238		98° 11' 19,777" E	47° 55' 5,522" N	
239		98° 11' 19,466" E	47° 54' 41,149" N	

Монгол Улсын Их Хурлын 2019 оны  
41 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

**Нөмрөгийн дархан цаазат газрын хилийн зааг**

№	Аймгийн нэр	Уртраг	Өргөрөг	Талбайн хэмжээ /га/
1	Дорнод	118° 53' 51,263" E	46° 46' 29,831" N	587744,74
2		118° 51' 17,994" E	46° 48' 45,368" N	
3		118° 50' 8,890" E	46° 50' 39,367" N	
4		118° 48' 4,586" E	46° 52' 43,365" N	
5		118° 45' 24,980" E	46° 55' 48,163" N	
6		118° 44' 1,874" E	46° 58' 31,462" N	
7		118° 44' 0,870" E	47° 0' 20,263" N	
8		118° 43' 2,062" E	47° 4' 25,463" N	
9		118° 43' 51,555" E	47° 7' 21,464" N	
10		118° 36' 25,147" E	47° 11' 43,357" N	
11		118° 34' 34,800" E	47° 14' 20,900" N	
12		118° 37' 28,231" E	47° 18' 45,360" N	
13		118° 42' 46,324" E	47° 21' 18,466" N	
14		118° 51' 14,258" E	47° 20' 32,627" N	
15		118° 57' 55,629" E	47° 17' 25,881" N	
16		119° 4' 13,587" E	47° 13' 57,244" N	
17		119° 10' 42,620" E	47° 13' 58,141" N	
18		119° 25' 51,945" E	47° 16' 31,285" N	
19		119° 28' 48,367" E	47° 19' 36,528" N	
20		Улсын хил дагуу		
21		118° 54' 17,201" E	46° 46' 28,499" N	

Монгол Улсын Их Хурлын 2019 оны  
41 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт

**Монгол дагуурын "Б" хэсгийн дархан цаазат газрын хилийн зааг**

№	Аймгийн нэр	Уртраг	Өргөрөг	Талбайн хэмжээ
1	Дорнод	114° 50' 7,442" E	49° 27' 20,112" N	102926,52
2		114° 49' 59,927" E	49° 33' 27,224" N	
3		114° 51' 20,000" E	49° 34' 42,000" N	
4		114° 51' 20,000" E	49° 38' 9,900" N	
5		114° 56' 8,707" E	49° 37' 56,092" N	
6		114° 58' 18,977" E	49° 39' 37,249" N	
7		115° 4' 45,476" E	49° 40' 58,040" N	
8		115° 6' 55,801" E	49° 41' 54,729" N	
9		115° 12' 8,334" E	49° 42' 48,823" N	
10		115° 13' 31,283" E	49° 42' 2,310" N	
11		115° 20' 27,087" E	49° 42' 59,548" N	
12		115° 26' 18,896" E	49° 42' 16,386" N	
13		115° 27' 38,216" E	49° 42' 17,732" N	
14		115° 34' 9,358" E	49° 43' 59,066" N	



15	115° 35' 33,401" E	49° 43' 30,777" N
16	115° 35' 24,777" E	49° 41' 58,808" N
17	115° 31' 3,605" E	49° 41' 24,311" N
18	115° 29' 8,881" E	49° 39' 51,174" N
19	115° 29' 49,700" E	49° 37' 48,700" N
20	115° 29' 13,200" E	49° 33' 38,200" N
21	115° 26' 22,100" E	49° 30' 49,500" N
22	115° 24' 32,300" E	49° 30' 52,900" N
23	115° 24' 32,200" E	49° 37' 31,050" N
24	115° 16' 57,200" E	49° 37' 31,030" N
25	115° 16' 57,300" E	49° 29' 32,020" N
26	115° 8' 36,400" E	49° 27' 16,400" N
27	115° 1' 31,200" E	49° 27' 9,200" N
28	114° 56' 45,400" E	49° 25' 47,900" N

Монгол Улсын Их Хурлын 2019 оны  
41 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралт

Булган гол-Их Онгогийн байгалийн цогцолборт газрын хилийн зааг

№	Аймгийн нэр	Уртраг	Өргөрөг	Талбайн хэмжээ /га/
1	Ховд	91° 0' 37,645" E	46° 7' 26,180" N	246081,88
2		Улсын хил дагуу		
3		91° 2' 46,577" E	46° 43' 11,473" N	
4		91° 5' 7,508" E	46° 42' 50,140" N	
5		91° 6' 53,388" E	46° 41' 18,635" N	
6		91° 8' 55,561" E	46° 41' 9,053" N	
7		91° 10' 12,750" E	46° 41' 9,250" N	
8		91° 11' 18,305" E	46° 40' 32,875" N	
9		91° 11' 47,772" E	46° 40' 14,108" N	
10		91° 11' 49,533" E	46° 39' 57,224" N	
11		91° 12' 59,177" E	46° 39' 57,498" N	
12		91° 16' 20,132" E	46° 39' 22,776" N	
13		91° 16' 17,592" E	46° 38' 37,477" N	
14		91° 18' 56,329" E	46° 35' 43,602" N	
15		91° 18' 44,690" E	46° 33' 57,821" N	
16		91° 22' 58,292" E	46° 33' 15,282" N	
17		91° 26' 4,920" E	46° 33' 38,958" N	
18		91° 27' 51,625" E	46° 34' 8,978" N	
19		91° 29' 31,722" E	46° 35' 19,477" N	
20		91° 30' 17,139" E	46° 39' 6,707" N	
21		91° 30' 54,575" E	46° 38' 32,965" N	
22		91° 33' 12,977" E	46° 36' 47,676" N	
23		91° 33' 31,666" E	46° 36' 21,699" N	
24		91° 35' 24,849" E	46° 35' 33,016" N	
25		91° 37' 35,383" E	46° 36' 58,964" N	
26		91° 41' 27,552" E	46° 37' 48,210" N	
27		91° 43' 50,978" E	46° 30' 13,499" N	



28	91° 41' 34,885" E	46° 26' 48,948" N
29	91° 38' 34,462" E	46° 24' 32,937" N
30	91° 36' 36,964" E	46° 23' 42,675" N
31	91° 37' 11,969" E	46° 20' 54,342" N
32	91° 35' 0,554" E	46° 19' 38,677" N
33	91° 36' 10,898" E	46° 16' 34,867" N
34	91° 35' 7,121" E	46° 15' 8,399" N
35	91° 32' 59,575" E	46° 13' 48,017" N
36	91° 30' 52,899" E	46° 14' 19,231" N
37	91° 29' 37,913" E	46° 14' 33,978" N
38	91° 28' 12,163" E	46° 15' 33,685" N
39	91° 25' 27,572" E	46° 16' 51,427" N
40	91° 24' 50,609" E	46° 17' 56,192" N
41	91° 23' 49,753" E	46° 19' 35,086" N
42	91° 23' 19,107" E	46° 19' 56,508" N
43	91° 22' 45,518" E	46° 19' 58,856" N
44	91° 19' 35,235" E	46° 18' 24,167" N
45	91° 16' 17,811" E	46° 16' 36,790" N
46	91° 13' 44,579" E	46° 14' 45,100" N
47	91° 11' 28,348" E	46° 11' 33,649" N
48	91° 10' 34,296" E	46° 9' 52,259" N
49	91° 10' 15,152" E	46° 9' 7,943" N
50	91° 14' 31,298" E	46° 5' 26,967" N
51	91° 14' 22,592" E	46° 4' 21,914" N
52	91° 7' 51,341" E	46° 4' 46,359" N

Монгол Улсын Их Хурлын 2019 оны  
41 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт

Тэсийн гол, Булнайн нурууны байгалийн цогцолборт газрын хилийн зааг

№	Аймгийн нэр	Уртраг	Өргөрөг	Талбайн хэмжээ /га/
1	Хөвсгөл, Завхан	98° 48' 49,259" E	49° 18' 27,970" N	369630.89
2		98° 51' 35,730" E	49° 18' 20,428" N	
3		98° 51' 43,000" E	49° 19' 24,000" N	
4		98° 54' 23,000" E	49° 19' 54,000" N	
5		98° 58' 51,000" E	49° 19' 41,000" N	
6		99° 1' 40,000" E	49° 18' 45,000" N	
7		99° 4' 4,000" E	49° 17' 30,000" N	
8		99° 6' 56,000" E	49° 17' 2,000" N	
9		99° 11' 40,000" E	49° 16' 34,000" N	
10		99° 13' 56,000" E	49° 16' 11,000" N	
11		99° 16' 31,000" E	49° 13' 59,000" N	
12		99° 13' 55,000" E	49° 10' 28,000" N	
13		99° 12' 44,000" E	49° 7' 27,000" N	
14		99° 7' 28,000" E	49° 6' 7,000" N	
15		99° 5' 23,000" E	49° 4' 37,000" N	
16		99° 2' 7,000" E	49° 4' 24,000" N	



17	98° 58' 7,000" E	49° 2' 46,000" N
18	98° 55' 20,000" E	48° 59' 45,000" N
19	98° 51' 55,000" E	48° 57' 39,000" N
20	98° 46' 51,000" E	48° 57' 21,000" N
21	98° 40' 15,000" E	48° 57' 5,000" N
22	98° 37' 44,000" E	48° 55' 13,000" N
23	98° 34' 9,000" E	48° 58' 27,000" N
24	98° 27' 6,000" E	49° 0' 26,000" N
25	98° 26' 26,000" E	49° 2' 24,000" N
26	98° 23' 57,000" E	49° 3' 1,000" N
27	98° 15' 41,000" E	49° 2' 9,000" N
28	98° 13' 23,000" E	49° 3' 26,000" N
29	98° 9' 33,000" E	49° 2' 18,000" N
30	98° 5' 26,000" E	49° 0' 24,000" N
31	98° 1' 19,000" E	49° 1' 1,000" N
32	97° 56' 14,000" E	49° 0' 26,000" N
33	97° 49' 21,000" E	49° 3' 11,000" N
34	97° 46' 40,000" E	49° 1' 25,000" N
35	97° 43' 57,000" E	48° 59' 39,000" N
36	97° 37' 39,000" E	48° 59' 28,000" N
37	97° 31' 51,000" E	49° 2' 25,000" N
38	97° 26' 47,000" E	49° 3' 44,000" N
39	97° 23' 12,000" E	49° 8' 51,000" N
40	97° 22' 24,000" E	49° 11' 35,000" N
41	97° 26' 49,000" E	49° 13' 0,000" N
42	97° 30' 14,000" E	49° 11' 32,000" N
43	97° 34' 32,000" E	49° 10' 32,000" N
44	97° 37' 54,000" E	49° 9' 45,000" N
45	97° 39' 23,000" E	49° 8' 50,000" N
46	97° 40' 20,000" E	49° 8' 23,000" N
47	97° 44' 48,000" E	49° 11' 11,000" N
48	97° 47' 31,000" E	49° 12' 55,000" N
49	97° 51' 46,000" E	49° 14' 5,000" N
50	97° 52' 35,000" E	49° 14' 46,000" N
51	98° 2' 57,000" E	49° 15' 44,000" N
52	98° 5' 15,000" E	49° 16' 43,000" N
53	98° 7' 59,000" E	49° 16' 9,000" N
54	98° 11' 45,000" E	49° 17' 5,000" N
55	98° 16' 11,000" E	49° 16' 48,000" N
56	98° 20' 51,000" E	49° 16' 53,000" N
57	98° 22' 13,000" E	49° 18' 45,000" N
58	98° 25' 45,000" E	49° 19' 44,000" N
59	98° 33' 23,000" E	49° 19' 20,000" N
60	98° 41' 24,000" E	49° 18' 8,000" N
61	98° 47' 21,131" E	49° 16' 59,661" N

Монгол Улсын Их Хурлын 2019 оны  
41 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралт

Дарьгангын байгалийн цогцолборт газрын хилийн зааг

№	Аймгийн нэр	Уртраг	Өргөрөг	Талбайн хэмжээ /га/
1	Сүхбаатар	114° 10' 53,102" E	45° 2' 7,297" N	367222,37
2		114° 10' 35,699" E	45° 2' 9,600" N	
3		114° 4' 45,405" E	45° 2' 57,409" N	
4		113° 55' 6,416" E	45° 10' 19,285" N	
5		113° 43' 45,512" E	45° 9' 56,406" N	
6		113° 35' 40,740" E	45° 11' 52,683" N	
7		113° 25' 15,096" E	45° 17' 30,842" N	
8		113° 29' 55,413" E	45° 19' 57,372" N	
9		113° 34' 51,192" E	45° 18' 24,675" N	
10		113° 38' 36,906" E	45° 16' 20,818" N	
11		113° 44' 25,035" E	45° 15' 56,154" N	
12		113° 48' 41,511" E	45° 17' 36,006" N	
13		113° 46' 29,676" E	45° 18' 52,292" N	
14		113° 50' 25,771" E	45° 19' 1,370" N	
15		113° 50' 21,514" E	45° 18' 29,935" N	
16		113° 49' 38,997" E	45° 18' 11,807" N	
17		113° 52' 8,576" E	45° 17' 54,600" N	
18		113° 52' 20,634" E	45° 17' 43,367" N	
19		113° 56' 19,916" E	45° 17' 17,796" N	
20		114° 0' 13,724" E	45° 17' 16,336" N	
21		114° 1' 57,244" E	45° 19' 15,023" N	
22		114° 3' 42,130" E	45° 24' 1,305" N	
23		114° 5' 11,824" E	45° 27' 20,626" N	
24		114° 1' 43,426" E	45° 29' 47,301" N	
25		114° 1' 35,809" E	45° 37' 39,125" N	
26		114° 4' 18,976" E	45° 42' 18,795" N	
27		114° 15' 36,307" E	45° 44' 43,696" N	
28		114° 21' 55,479" E	45° 46' 57,895" N	
29		114° 29' 26,385" E	45° 50' 11,324" N	
30		114° 32' 16,065" E	45° 47' 29,273" N	
31		114° 33' 47,204" E	45° 39' 20,783" N	
32		114° 44' 13,898" E	45° 26' 14,399" N	
33			Улсын хил дагуу	



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 05 дугаар  
сарын 23-ны өдөр

Дугаар 49

Улаанбаатар  
хот

### **Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, 22.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Төмөрбаатарын Аюурсайханыг сонгосугай.

2.Улсын Их Хурлын гишүүн Отгонбилэгийн Содбилэгийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

3.Энэ тогтоолыг 2019 оны 05 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 05 дугаар  
сарын 23-ны өдөр

Дугаар 50

Улаанбаатар  
хот

### **Цахим бодлогын түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.1.5 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Ёндонпэрэнлэйн Баатарбилэг, Болдын Жавхлан, Гомбожавын Занданшатар, Лхагвын Мөнхбаатар, Цэндийн Мөнх-Оргил, Загдхүүгийн Нарантуяа, Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ, Ганзоригийн Тэмүүлэн, Дамдины Цогтбаатар, Лхагваагийн Элдэв-Очир, Бямбасүрэнгийн Энх-Амгалан нарыг Цахим бодлогын түр хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2019 оны 05 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2019 оны 2 дугаар  
сарын 13-ны өдөр

Дугаар 69

Улаанбаатар

### **Үндэсний хөтөлбөр батлах тухай**

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.3-т заасныг үндэслэн Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2. “Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгт үүрэг болгосугай.

3. “Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын төсвийн багцад жил бүр тусган, олон улсын байгууллага, гадаадын зээл тусламжид хамруулах, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**У.ХҮРЭЛСҮХ**

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААН, СПОРТЫН САЙД**

**Ё.БААТАРБИЛЭГ**



Засгийн газрын 2019 оны 69 дүгээр  
тогтоолын хавсралт

“ЧУЛУУН СОЁЛЫН ӨВ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Чулуун соёлын өв нь хүн төрөлхтний хөгжлийн түүхийн тодорхой цаг үеийн гэрч болон үлдэж, хүмүүсийн нийгмийн байдал, оюуны соёлын түвшин, зан заншил, шашин шүтлэг болон ахуй амьдралын улирч мартагдсан түүхийг нэхэн сэргээж ойлгох гол эх сурвалж болдог, дэлхий нийтийн үнэ цэнэтэй дурсгал юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж, Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 1.1.6-д “Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа мөн” гэж, Улсын Их Хурлын 2012 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого”-ын 4.3.2-т “эрт эдүгээгийн соёлын өв санг үндэсний эрхэм баялаг болохын хувьд төрийн хамгаалалтад байлгах” гэж тус тус заасан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны “Хадны зураг, бичээсийг хамгаалах, судлах ажлыг дэмжих тухай” 181 дүгээр зарлигт хадны зураг, бичээсийг хадгалж хамгаалах, дэлхий дахинаа сурталчлан таниулах, аялал жуулчлалын шинэ хэлбэрийг хөгжүүлэх зорилгоор өргөн хүрээтэй, үр дүнтэй ажил зохион байгуулахыг бүх шатны засаг захиргааны байгууллагууд, төрийн болон төрийн бус байгууллага, шинжлэх ухаан, нийгэм соёлын зүтгэлтнүүд, аялал жуулчлалын байгууллага, ард иргэдэд уриалсан байна.

2015 онд улсын хэмжээнд явуулсан үзлэг, тооллогын дүн мэдээгээр манай улсын нутаг дэвсгэр дээр 4230 хөшөө чулуу, 6796 хадны зураг, бичгийн дурсгал бүртгэгдсэний ихэнх нь байгаль, нийгмийн хүчин зүйлийн нөлөөгөөр их бага хэмжээгээр эвдэрч гэмтсэн байна. Ялангуяа цаг уурын өөрчлөлт, уул уурхай, зам харилцаа зэрэг шинэ бүтээн байгуулалт, аялал жуулчлал, шашин шүтлэгийн нөлөөгөөр чулуун соёлын өвд хохирол учрах явдал түгээмэл тохиолдож байна.

Чулуун соёлын өвийг хамгаалахад өмнө тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхийн тулд санхүүгийн болон хүний нөөц, техник технологийн боломжид үндэслэн тодорхой дурсгалуудыг сонгон хамгаалах, сэргээн засварлах арга хэмжээг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулсан арга

зүйн дагуу гүйцэтгэх, дурсгалыг цаашид хэрхэн хамгаалах талаар хэтийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, аялал жуулчлалтай уялдуулан хөгжүүлэх, гадаад, дотоодод сурталчлах зэрэг цогц арга хэмжээ авах шаардлагатай байна.

## Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа

2.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр оршин байгаа түүх, соёл, шинжлэх ухааны хувьд чухал ач холбогдолтой хадны зураг, бичээс, буган чулуун хөшөө, хүн чулуун хөшөө, тамга тэмдэг, бичээс бүхий хөшөө, амьтны дүрст чулуун дурсгал, зураг, тамга бүхий хавтан чулуун дурсгалууд зэрэг чулуун соёлын өвийг бүртгэн баримтжуулах, судалж шинжлэх, хадгалж хамгаалах, сэргээн засварлах, сурталчлан таниулах, зохистой ашиглах замаар чулуун соёлын өвийн оршин тогтнох чадавхыг бэхжүүлж, хамгаалахад хөтөлбөрийн зорилго оршино.

## 2.2. Хөтөлбөрийн хүрээнд дараахь зорилтыг хэрэгжүүлнэ:

- 2.2.1. Чулуун соёлын өвийг бүртгэн баримтжуулах;
- 2.2.2. Чулуун соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлах;
- 2.2.3. Чулуун соёлын өвийг сурталчлах;
- 2.2.4. Чулуун соёлын өвийг түшиглэсэн аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох.

## 2.3. Хөтөлбөрийг 2019-2024 онд хэрэгжүүлнэ.

## Гурав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Чулуун соёлын өвийг бүртгэн баримтжуулах зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

3.1.1. чулуун соёлын өвийг бүртгэн баримтжуулах, мэдээлэл цуглуулах арга зүйг боловсронгуй болгох;

3.1.2. чулуун соёлын өвийг бүртгэн баримтжуулах ажлыг дурсгалын төрлөөр бүсчлэн зохион байгуулах;

3.1.3. зарим томоохон цогцолбор дурсгалын оршин байгаа газрыг кадастрын улсын бүртгэлд бүртгүүлэх;

3.1.4. зарим цогцолбор дурсгалыг Дэлхийн соёлын өвийн жагсаалтад нэр дэвшүүлэх.



3.2. Чулуун соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлах зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

3.2.1. чулуун соёлын өвийн хэв, дардасыг авах, хуулбарыг хийж хадгалах;

3.2.2. чулуун соёлын өвийг цэвэрлэж бэхжүүлэх, сэргээн засварлах;

3.2.3. чулуун соёлын өвийн хамгаалалтын хайс, хашаа барьж, танилцуулга байрлуулах;

3.2.4. чулуун соёлын өвийн устах эрсдэлд орсон дурсгалыг унаган газраас нь зөөж тээвэрлэн аюулгүй газарт шилжүүлэн байрлуулах;

3.2.5. чулуун соёлын өвийн чулуулгийн бүтцийн болон эвдрэл гэмтлийг нарийвчлан судалж тодорхойлох лаборатори байгуулах.

3.3. Чулуун соёлын өвийг сурталчлах зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

3.3.1. чулуун соёлын өвийн талаар баримтат кино бүтээж сурталчлах;

3.3.2. судалгаа, сурталчилгааны ном, бүтээл хэвлүүлэх;

3.3.3. дотоод, гадаадад тусгай үзэсгэлэн зохион байгуулах.

3.4. Чулуун соёлын өвийг түшиглэсэн аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

3.4.1. чулуун соёлын өвийн талаар хөтөч, тайлбарлагчдын мэдлэгийг дээшлүүлэх;

3.4.2. зарим томоохон цогцолбор дурсгалыг түшиглэн музей, ил үзвэрийн газар байгуулах;

3.4.3. чулуун дурсгалыг түшиглэсэн аяллын маршрут бий болгож хөгжүүлэх.



## Дөрөв. Хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт

№	Зорилт	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин	
				Он	Үзүүлэлт	Он	Үзүүлэлт
Бодлогын баримт бичгийн үр дүнг үнэлэх бусад шалгуур үзүүлэлтүүд							
1	1. Чулуун соёлын өвийг бүртгэн баримтжуулах	шинэ арга зүйгээр бүртгэл хийж, цахим хэлбэрт нэвтрүүлсэн байдал	тоо	2019	11026	2024	12000
		бүртгэн баримтжуулсан дурсгал	тоо	2019	3000	2024	5000
		кадастрын бүртгэлд бүртгэгдсэн байдал	тоо	2019	-	2024	10
		дэлхийн соёлын өвд нэр дэвшүүлж, бүртгэгдсэн өв	тоо	2019	3	2024	5
2	2. Чулуун соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлах	хэв, дардас, хуулбар авч хадгалсан өв	тоо	2019	8	2024	20
		сэргээн засварлаж, цэвэрлэж бэхжүүлсэн өв	тоо	2019	20	2024	27
		хамгаалалтын хашаа, танилцуулга самбар байршуулсан өв	тоо	2019	8	2024	14
		аюулгүй газарт шилжүүлсэн байдал	тоо	2019	12	2024	17
		тоног төхөөрөмж, лабораторийн хүчин чадал	хувь	2019	10%	2024	50%
3	3. Чулуун соёлын өвийг сурталчлах	баримтат кино бүтээл	тоо	2019	3	2024	7
		хэвлэгдсэн ном бүтээл	тоо	2019	10	2024	25
		зохион байгуулсан үзэсгэлэн	тоо	2019	-	2024	3
4	4. Чулуун соёлын өвийг түшиглэсэн аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох	хэвлүүлсэн гарын авлага	тоо	2019	-	2024	250
		шинээр байгуулсан музей	тоо	2019	-	2024	2
		шинээр бий болсон маршрут	тоо	2019	-	2023	3

## Тав. Хөтөлбөрийн санхүүжилт

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

- 5.1.1. улсын болон орон нутгийн төсөв;
- 5.1.2. гадаадын зээл, буцалтгүй тусламж;
- 5.1.3. гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;
- 5.1.4. иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хандив;



5.1.5. хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

Зургаа. Хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээ

6.1. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.7-д заасны дагуу жил бүр зохион байгуулж, тайланг дараа оны 1 дүгээр улиралд багтаан Засгийн газарт танилцуулна.

6.2. Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хяналт, шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжид үндэслэн хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах болон шаардлагатай бусад арга хэмжээ авах ажлыг зохион байгуулна.

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 1.75

**Индекс: 200003**